



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 8/79

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын
газрын данс бүртгэлээс тээврийн
хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1629 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 9,800,000 (есөн сая найман зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөнхуяг)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлтийг хийж, авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөнхуяг)-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (М.Мөнхбаяр)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500299



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2024 оны... дугаар сарын...-ны өдрийн
... дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах тээврийн хэрэгсэл

№	Байгууллагын нэр	Автомашин марк, улсын дугаар	Үйлдвэрлэсэн он, Монголд ашиглаж эхэлсэн огноо	Арлын дугаар	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Сэлбэг буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдах доод үнэ /төгрөг/
1	Баянгол дүүргийн ЗДТГазар	Тоёота эстима 69-54УНД	2002/2013	АНР102001833	9,800,000	9,800,000	0,00	500,000
	Дүн				9,800,000	9,800,000	0,00	